



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д 7  
оруулсан нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup>.9 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 327 дугаар тогтоолоор зөвшөөрч, 2011 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 346 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 3, 4, 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.6, 4.2.5, 8.2 дахь хэсгийг тус тус нэмэхийг зөвшөөрсүгэй:

1/ “3.6. Даатгагч нь Холбооны гишүүнээр элсэх үүргээ хэрэгжүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

3.6.1. Холбооноос тогтоосон стандартын дагуу гаргасан өргөдөл;

3.6.2. компанийн дүрмийн хуулбар;

3.6.3. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.6.4. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шийдвэр, гэрчилгээний хуулбар;

3.6.5. элсэлтийн хураамж төлсөн баримт;

3.6.6. компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцийн байдал;

3.6.7. компанийн гүйцэтгэх захирлыг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.6.8. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу гаргасан компанийн санхүүгийн тайлан, төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайлан, нөөц сангийн тайлан /сүүлийн жилийн болон улирлын байдлаар/;

3.6.9. компанийн салбарын мэдээлэл.” гэж;

2/ ”4.2.5.Элсэлтийн хураамжийг Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчид албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор, гишүүний татварыг тухайн жилийн 1 дүгээр сард багтаан төлөх.” гэж;

3/ “8.2.Холбооны гишүүний элсэлтийн хураамж болон дараа жилд төлөх татварын хэмжээг жил бүрийн 12 дугаар сард багтаан Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтооно.” гэж.

2. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “... гаргана.” гэсний дараа “Удирдах зөвлөл тухайн даатгагчийн гишүүнчлэлийн асуудлаар хуралдаж шийдвэр гаргана.” гэж нэмэхийг зөвшөөрсүгэй.

3. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн дугаарыг 8.3 гэж, 8.3 дахь хэсгийн дугаарыг 8.4 гэж, 8.4 дэх хэсгийн дугаарыг 8.5 гэж тус тус өөрчилсүгэй.

4. ”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл/Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН